

Монгол улсын мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хөгжлийн стратегийн асуудал

Д.Чимгээ

МУИС, ЭЗС-ийн Математик, компьютерийн тэнхмийн багш, доктор, дэд профессор

Ц.Ганбат

ШУТИС, КТМС-ийн багш, доктор, дэд профессор

Удиртгал

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих тухай тусгасан. Үндэсний хөгжлийн цогц бодлогод хүрэх үр дүнг:

- 2007-2015 онд МХЗ-ыг хангах эдийн засгийн эрчимтэй хөгжлийн үе шат
- 2016-2021 онд Мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжилд шилжих үе шат гэсэн хоёр үр шаттай авч үзжээ.

Энэхүү цогц бодлогод Монгол Улс “Хүний хөгжил, аюулгүй байдлыг хангадаг мэдлэгт суурилсан эдийн засаг бүхий тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг сонгосон бөгөөд энэ нь монгол хүн өөрөө тасралтгүй сурч, боловсрон нийгмийн баялгаас хүртэх чадвартай байхын зэрэгцээ эдийн засгийн түргэн өсөлтөөр хүний ажиллах, амьдрах орчны сонголтыг өргөжүүлэн бүтээх явдал бөгөөд хүний хөгжил, мэдлэгт суурилсан эдийн засгийн өсөлт нь байгаль орчинд дарамтгүй, халгүй байх ёстой” хэмээн заажээ.

Монгол улс мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих үе шат (2016-2021)-д

- Эдийн засаг жилд дунджаар 12-оос доошгүй хувиар өсч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдхүүн (ДНБ) 12 мянгаас доошгүй ам. долларт хүрч, оюуны шингэц бүхий үйлдвэрлэл,

үйлчилгээ өргөжиж, мэдлэгт суурилсан эдийн засаг төлөвшин хөгжиж, Монгол Улс дэлхийн дундаж орлоготой орнуудын эгнээнд орно.

- Монгол Улсын эдийн засаг нь бүхэлдээ үлэмж үр ашигтай, өрсөлдөх чадвартай болно.
- Ашигт малтмалын олборлолтоос бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шилжих үйл явц эрчимжинэ.
- Улсын хэмжээнд жилд дунджаар 15000-аас доошгүй айл өрх орон сууцны нөхцлөө сайжруулна.
- 2021 он гэхэд дундаж орлоготой иргэдийн эзлэх хувийн жин 60 хувьд хүрч, хүний хөгжлийн индекс 0.8 болно.
- 2021 он гэхэд бүх шатны сургуульд хамран сургалт 100 хувьд хүрнэ.
- Олон улсын стандартад нийцсэн хөтөлбөртэй ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн тоо нэмэгдэнэ.
- Судалгаа боловсруулалтын санхүүжилтийн хэмжээг 2015 он гэхэд ДНБ-ий 2 хувьд, 2021 он гэхэд 3 хувьд хүргэнэ. Энэ зардлын 1/3-ийг хувийн хэвшил санхүүжүүлдэг болно.
- Орчин үеийн технологи эзэмшсэн, нутагшуулсан орон болно.
- Аялал, жуулчлалын салбар хөгжиж, жилд ирэх жуулчдын тоо хүн амын тоотой тэнцэнэ.

- Эрчимжсэн хөдөө аж ахуй, фермерийн аж ахуй хөгжиж, хүн амын хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг үндсэнд нь дотоодын экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангаж, хүнсний бүтээгдэхүүний экспорт өснө.
- Нефтийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангана.
- Ази тив, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай, орчин үеийн тээвэр холбоо, эрчим хүчний дэд бүтэц бий болно. Хатуу хучилттай авто замын урт 11000 км-т хүрнэ. Хоёрдох төмөр замыг ашиглалтанд оруулна. Баруун, Говийн болон Зүүн бүсэд төмөр замын сүлжээ бий болно.
- Монгол Улс 2021 он гэхэд цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээгээ дотоодын эх үүсвэрээр найдвартай бүрэн хангаад зогсохгүй, цахилгаан эрчим хүчийг дэлхийн зах зээлд нийлүүлдэг орон болно.
- Бүсийн тулгуур төв хотууд хөгжин, хүн ам нь тус бүр 100 мянгаас доошгүй болж, орон нутагтаа тогтвор суурьшилтай аж төрөх таатай орчин бүрдэнэ.
- Хүн амын дундаж наслалт 72 болно.
- Сум, аймгийн эмнэлэгүүдийн хэрэгцээ 100 хувь хангагдана.
- Хөдөөнөөс оношилгоо, эмчилгээнд зорчигчдын тоо 95 хувиар буурна.
- Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар 95 хувьд хүрнэ.
- Нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээ оновчтой болж, үр ашиг нь дээшилсэн зэрэг хүрэх үр дүнгүүдийг тодорхойлсон байна.

Цогц бодлогод тодорхойлсон эдгээр үр дүнд хүрэхийн тулд Монгол Улсын

дунд болон богино хугацааны хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны болон Монгол Улсыг дэмжигч олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдэд нарийвчлан тусган хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар гүйцэтгэж байгаа билээ.

Бидний шилжих гэж зорьж буй мэдлэгт суурилсан эдийн засаг гэж юуг хэлээд байна вэ? Мэдлэгт суурилсан эдийн засаг нь мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагаанаас гаралтай ажээ. Хуучин үйлдвэржилтийн эдийн засгийг мэдлэгт суурилсан эдийн засгийн чиглэл рүү өөрчилж буй 3 үндсэн том хүчин зүйл байна. Үүнд:

Мэдлэг-компанид чухал ач холбогдолтой шийдвэр гаргах, үйлдэл хийхэд хүмүүсийн ашиглаж буй ойлголтуудын цогц, стратегийн чухал хүчин зүйл болох оюуны хөрөнгө.

Өөрчлөлт-тасралтгүй, үргэлжилсэн, улам нарийн болж буй, тодорхойгүй байдлыг үүсгэдэг, тааварлах, урьдчилан харах боломж

Даяаршил-судалгаа шинжилгээ, хөгжил, технологи, худалдса, санхүү, мэдээлэл, харилцаа холбоо нь эдийн засгийн нээлттэй байдал, өрсөлдөөн, бизнесүүдийн хоорондын хамаарал зэрэг юм.

Мэдлэгт суурилсан эдийн засаг ба хуучин үйлдвэржилтийн эдийн засгийн хоорондох ялгааг дэлхийн эрдэмтэн судлаачид дараах байдлаар тодорхойлж байна.

**Хүснэгт 1. Мэдлэгт суурилсан эдийн засаг ба хуучин үйлдвэржилтийн эдийн засгийн
хоорондох ялгаа**

Асуудлууд	Хуучин үйлдвэржилтийн эдийн засаг	Мэдлэгт суурилсан шинэ эдийн засаг
А. Зах зээл		
Эдийн засгийн өсөлт	Тогтмол шулуун урьдаас таамаглагдсан	Хувирамтгай, огцом өсөлт, бууралт бүхий туйлын хурдан өөрчлөгддөг, эдийн засгийн өсөлтийн чиглэл нь яг тодорхой биш эмх замбараагүй
Зэх зээлийн өөрчлөлт	Удаан ба шулуун	Хурдан ба таамаглах боломжгүй
Эдийн засаг	Нийлүүлэгчээс хамаарсан	Худалдан авагчаас хамаарсан
Бүтээгдэхүүн, технологийн амьдралын мөчлөг	Урт	Богино
Эдийн засгийн гол чиглүүлэгч	Том үйлдвэржсэн пүүс, компаниуд	Шинийг санаачлагч мэдлэгт суурилсан пүүс, компаниуд
Өрсөлдөөний цар хүрээ	Орон нутгийн	Глобалчлагдсан, асар ширүүн өрсөлдөөн
Өрсөлдөөний тоглоомын нэр	Хэмжээ: Хүчтэй нь хүчгүйгээ иддэг	Хурд: Хурдан нь удаанаа иднэ
Маркетингийн тоглоомын нэр	Нийтийн маркетинг	Ялгаатай маркетинг
Б. Үйл ажиллагаа		
Бизнесийн хурд	Удаан	Хэрэглэгчдийн хүлээлт, таамаглалаас үргэлж түрүүлж байх
Гол цөм	Тогтворжилт	Өөрчлөлтийн удирдлага
Бизнесийн хөгжлийн хандлага	Пирамид стратеги: алсын хараа, эрхэм зорилго, зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд	Боломжоор чиглэгдсэн, өөрчлөмтгий стратеги
Амжилтын хэмжүүр	Ашиг	Нийт компанийн зах зээлийн үнэ цэнэ
Үйлдвэрлэлийн зохион байгуулалт	Бөөний үйлдвэрлэл	Уян хатан, өөрчлөмтгий үйлдвэрлэл
Өсөлтийн гол чиглүүлэгч	Хөрөнгө	Хүмүүс, мэдлэг, чадвар
Шинэчлэлтийн гол нөөц	Судалгаа	Судалгаа, системтэй шинэчлэлт, мэдлэгийн менежмент, уялдсан шинэ бизнесийг үүсгэх, шинэ бизнесийн загварууд
Технологийн гол чиглүүлэгч	Автоматжуулалт, механикжуулалт	Мэдээлэл, харилцаа холбооны технологи, е-бизнес, компьютержсэн загварчлал ба үйлдвэрлэл

Өрсөлдөх давуу талын гол нөөц	Түүхий эд материал, хямд ажлын хүч, хэмнэлтээр зардлыг бууруулах	Онцгой чадвар: багаар ажиллах чадвар, хурдтай шилжих, хүний нөөц, хэрэглэгчидтэй харьцах, стратегийн өөрчлөлт
Ховор нөөц	Санхүүгийн хөрөнгө	Хүний хөрөнгө
Шийдвэр гаргалт	Босоо	Хуваарилагдсан
Шинэчлэлтийн үйл явц	Үечилсэн, шулуун	Үргэлжилсэн, системтэй
Үйлдвэрлэлийн гол анхаарал	Дотоод үйл ажиллагаа	Компаний хэмжээгээр бизнесийн үйл ажиллагааны удирдлага
Бусад компаниудтай хамтран ажиллах стратеги	Зөвхөн ганцаараа	Нэмэлт нөөцийг ашиглахад хамтран ажиллах
Бүтэц, зохион байгуулалт	Шаталсан, пирамид бүтэц	Хоорондоо уялдсан дэд системүүд, уян хатан, ажилтнуудын чадавхи, хавтгай сүлжээ бүтэц
Бизнесийн загвар	Уламжлалт: захирах, хянах	Шинэ: хүмүүс, мэдлэгт анхаарсан
С. Ажиллах хүч		
Манлайлал	Босоо	Ажилтнуудын чадавхи, өөрсдөө манлайлах
Ажиллах хүчний хэв шинж	Ихэвчлэн эрэгтэй, хагас болон чадваргүйчүүдийн эзлэх хувь өндөр	Хүйсийн ялгаагүй, мэргэжсэн хүмүүсийн эзлэх хувь өндөр
Ур чадвар	Ганцхан зүйлээр дагнасан, стандартчлагдсан	Олон талын чадвартай, уян хатан
Боловсролын шаардлага	Ур чадвар эсвэл зэрэг	Тасралтгүй суралцах,
Удирдлага ажилтны харьцаа	Сөргөлдсөн	Хамтран ажиллах, багаар ажиллах
Ажил эрхлэлт	Тогтвортой	Зах зээлийн бөмөрлөөс хамаарна
Ажилтныг үзэх хандлага	Зардал	Хөрөнгө оруулалт

Дээрх хүснэгтээс харахад дэлхий дахины байна.

эдийн засаг, зах зээлийн харилцаанд мэдээлэл, хүн, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний хил хязгааргүй урсгалд суурилсан шинэ нөхцөл байдал бүрэлдэж байгаа энэ үед дэлхийн улс орнууд мэдлэгт суурилсан эдийн засгийг байгуулахын тулд хүний хөгжил, нийгэм эдийн засгийнхаа өсөлтийн хэтийн төлвийг даян дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн явцтай нягт уялдуулах шаардлагатай болсон байна.

Тэгвэл дэлхийн улс орнуудын мэдлэгт суурилсан эдийн засгийг ямар шалгуураар үнэлэх вэ? хэмжих вэ? гэдэг асуудал гарч

1998 оноос Дэлхийн банкнаас мэдлэгт суурилсан эдийн засгийг байгуулах асуудалд ихээхэн анхаарч ирсэн байна. Үүний нэг жишээ бол Дэлхийн Банкны Knowledge for Development (KD) программ нь дэлхийн улс орнуудад “Мэдлэгийн хувьсгал”-ыг хийхэд туслах зорилготой хөтөлбөр байв. Энэхүү хөтөлбөрийн дагуу мэдлэгт суурилсан эдийн засгийн үзүүлэлтүүдийг 4 үндсэн багцад хуваан авч үзжээ. Үүнд:

- Эдийн засаг ба хууль дүрэм
- Боловсролтой хүн ам


- Үр ашигтай инновацийн систем
- Мэдээлэл, холбооны технологийн дэд бүтэц

Дээрх багц үзүүлэлтүүд Дэлхийн Банкны Knowledge Assessment Methodology (KAM) буюу мэдлэгийг үнэтэх арга зүйд орсон бөгөөд одоогийн байдлаар үүнд 83 бүтцийн болон чанарын үзүүлэлтүүдийг оруулж дэлхийн 140 орны хувьд мэдлэгийн эдийн засгийн индексийн (Knowledge Economy Index-KEI, Knowledge Index-KI) тооцоог гаргаж байна (Хавсралт 1-ээс харна уу). Эдгээр үзүүлэлтийн дагуу төсөөлж байгаа хамгийн сайн гэсэн зураглалтай зэрэгцүүлэн дэлхийн улс орнуудын мэдлэгийн эдийн засгийг байгуулах чиглэлээр гүйцэтгэлийг хэмжиж байна. Тооцоог янз бүрийн аргаар хийж байгаа бөгөөд үүний нэг арга нь 14 үндсэн үзүүлэлтээр дэлхийн улс орнуудын

мэдлэгийн эдийн засгийн индексийг бодож тэдгээрийг өөр хооронд нь харьцуулан үзэж байна.

Монгол Улсыг бусад улсуудтай харьцуулахад ямар байдалтай байна вэ?


Дэлхийн банкны дээрх судалгаагаар мэдлэгийн эдийн засгийн индексээр Монгол Улс 140 орноос 1995 онд 98-р байранд байсан бол 2007 онд 79-р байранд орсон байх бөгөөд уг судалгааны тайланд энэ байдлыг доогуур орлоготой орнуудаас хамгийн өндөр хөгжил дэвшилхийсэн хэмээн үнэлжээ. Гэхдээ хөгжил дэвшлийн үндэс болгон худалдааны саад тотгорыг багасган, зохицуулалтын чанарыг сайжруулсан, хүн амын боловсролын түвшин харьцангуй өндөр зэргийг тайлбарт дурьдсан байна (Хавсралт 1).



Зураг 1. Монгол улсын Мэдлэгийн Эдийн Засгийн Индекс 1995, 2007


1000 хүнд ногдох компьютерийн тоог 1995 онтой харьцуулахад эрс өссөн ч хөгжилтэй орнуудтай харьцуулахад энэ нь хангалтгүй үзүүлэлт юм.

1000 хүнд ногдох телефон утас болон интернет хэрэглэгчдийн тоогоор АНУ, Шинэ Зеланд, Хятад зэрэг орнуудтай харьцуулахад бид доогуур явж байна.



Зураг 2. Монгол, АНУ, Хятад улсын Мэдлэгийн Эдийн Засгийн Индекс, 2007

Дэлхийн Банк дээд боловсролыг тухайн улсын хөгжлийн стратегийн чухал нэг бүрэлдэхүүн гэж үзсэн. Дэлхийн Банкны жишгээр улс орны дээд боловсролын чадавхийг математик, байгалийн шинжлэх ухаанд нээлт хийсэн байдал, шинэ технологи бүтээж, патент, лиценз эзэмшсэн байдал, судлаачдын бүтээлийг олон улсын нэр хүндтэй сэтгүүлд иш гатсан байдал гэх мэт чанарын үзүүлэлтээр үнэлж байна. Гэтэл энэ үзүүлэлтээр манай улс хангалтгүй байна (Хавсралт 2-оос харна уу).



Зураг 3. Шинэ Зеланд, Хятад, Монгол улсын Мэдлэгийн Эдийн Засгийн Индекс, 2007

Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудад өндөр мэдлэг боловсрол, үр дүнтэй багаар ажиллах чадвар, шинийг санаачлагч ажилтанг өндөр технологитой хослуулан ихээхэн амжилтанд хүрч байна. Эдгээр улсуудын мэдлэгийн эдийн засгийг байгуулах хөгжлийн стратегиудыг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Дэлхийн улс орнуудын мэдлэгийн эдийн засгийг байгуулах хөгжлийн стратегиуд

Улсын стратеги	Тэргүүлэх ач холбогдол
АНУ Асар хурдтай мэдээллийн өргөн зурвас	- Дараагийн үеийн интернетийг санхүүжүүлэх; - Үйлчилгээ болон хэрэглээний хөгжил; - Судалгаа, эрдэм шинжилгээг Засгийн газраас санхүүжүүлэхэд дэмжих; - Эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын онцгой холболт, үйлчилгээ;
Канад Мэдээллийн өргөн зурвас	- Байгаа дэд бүтцийг шинэчлэх; - Мэдээллийн Технологийн салбарын хүчтэй өрсөлдөөнийг мэдээллийн өргөн зурвасын хөгжилтэй холбох; - Улсын соёл, ёс заншил, агуулга болон хандалтыг хөхүүлэн дэмжих; - Засгийн газар үйлчилгээ, хангамжийн гол хүргэгч;
Их британи улс Мэдээлжсэн нийгэм	- Худалдааны тарифын бус саад тотгоруудын эрсдэлийг багасгах; - Дэд бүтцийн өрсөлдөөн; - Мэдээллийн технологийн хөгжлийг эдийн засгийн (бүсийн) хөгжилтэй маш нягт уялдуулах; - Салбарын сургалтын хэрэгцээг бүрэн хангах;
Сингапур Оюунлаг арал	- Үйлчилгээ, хэрэглээний хөгжлийг хангах дэд бүтцийг сайжруулах; - Шилэн кабелийн сүлжээний хөгжил, хөрөнгө оруулалтын төслүүдийг дэмжих; - Засгийн газраас тоон гарын үсэг болон боловсролын хөгжлийн индексийн хүрээнд хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх;
Япон Мэдээлжсэн нийгэм, мэдээлэл холбооны дэд бүтэц	- Өрсөлдөөн дээр үндэслэсэн дэд бүтцийн хөгжил - Хотын нягтралыг багасгаж, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх; - Жижиг Дунд Үйлдвэрлэлийг интернет ашиглахыг дэмжих; - Засгийн газраас судалгаа, туршилтын ажлуудыг санхүүжүүлэх;
Солонгос Мэдээлжүүлэх	- Улсын болон хувийн сүлжээнүүдэд суурилсан дэд бүтцийг хөгжүүлэх; - Сүлжээний хөгжил, төслүүдийг санхүүжүүлэх;
Монгол Мэдээлжсэн нийгэм	- Дэд бүтцийг хөгжүүлэх, хөдөө орон нутгийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах; - Судалгаа, туршилтын санхүүжилтэнд дэмжлэг үзүүлэх; - Программ хангамжийн салбарт түлхүү хамтран ажиллах; - Электрон засаглал, e-бизнесийг хөгжүүлэх; - Аутсорсингийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Дээрх байдлаас харахад мэдлэгийн эдийн засгийг байгуулахын тулд улс орнууд бүгд хоорондоо ижил төстэй шинжүүдийг агуулсан байна. Үүнд:

- Үр ашигтай, хямд харилцаа холбооны сүлжээ;
- Мэдээлэл, нэмүү өртөгт бизнесээр дамжуулан бүтээмжийг дээшлүүлсэн;
- Салбарын болон арилжааны өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн;
- Мэдээллийн үйлчилгээний салбарыг дэмжсэн;
- Тасралтгүй суралцах, чадваржуулах боловсрол, сургалтанд хөрөнгө оруулалт хийхэд анхаарсан;
- Хүн амыг мэдээлжүүлж, ардчиллын үйл ажиллагаанд оролцуулсан;
- Соёл, ёс заншлын үнэт зүйлийг дэмжсэн стратегиудыг тодорхойлсон байна.

Бид цаашид мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэхэд юунд голлон анхаарвал зохистой вэ?

Монгол Улсын хувьд тодорхойлсон стратегиудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд шаардлагатай үндэсний тэргүүлэн манлайлах чадавх бий болгох хэмжээнд хүртэл төр, засгийн үйл ажиллагааны чиглэлийг шинэтгэх нь чухал юм.

Бид дараах асуудлуудад анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Мэдлэгт Суурилсан Эдийн Засагт шилжих шилжилтийн стратеги асуудлуудыг тодорхойлохын зэрэгцээ хүрэх үр дүнгээ таамаглах, ойролцоо аргаар тооцох, хүрэх боломжит хувилбаруудаа гаргах, томоохон ажлын баг гаргаж судалгааг эхлүүлэх
2. Мэдлэгт Суурилсан Эдийн Засгийн

хүний нөөцийн хөгжлийн асуудлыг шинэ нийгмийн онцлог, эрэлт, шаардлагыг судлах, мэдээллийг баялаг болгох шинэ ажил, үйлчилгээг бий болгох, бизнесийн шинэ моделиуд гаргах мэдлэг, чадвартай мэргэжилтэн бэлтгэх

3. Байгууллагуудын электрон бэлэн байдлын үзүүлэлтийг сайжруулах, одоогийн бидний дундаж үзүүлэлтийг дээд үзүүлэлт болох 4.0 рүү дөхүүлэх мэдээллийн харилцаа холбооны дэд бүтцийн бэлэн байдлыг дээшлүүлэх
4. Улсын хэмжээний эдийн засгийн хөгжлийг тодорхойлогч үзүүлэлтүүдийг шинэ арга зүйгээр тодорхойлох, мэдээллийн эх үүсвэрийн харилцан хамаарал, хэрэглэгчдийн өгөгдөлд хандах эрхүүдийг ялгаатай тодорхойлох
5. Байгууллагын түвшинд хүний тархинд хадгалагдаж боловсрогдсон үнэтэй мэдээллийг байгууллагын өмч болгон электрон төхөөрөмжинд хадгалж авч үлдэх, улмаар мэдээллийн технологийн тусламжтайгаар шинжилгээ хийж, удирдлагад нэнхэрэгцээтэй тайлангуудыг гаргаж авах эдийн засаг, математикийн, статистикийн, эконометрикийн хүчтэй аппаратуудтай программ хангамжуудыг бий болгох, мэдээлэл дээр өндөр бүтээмжтэй ажиллах технологиудыг байгууллагын дотоод үйл ажиллагааг боловсронгуй болгоход хэрэглэх мэдлэг, чадвартай хүмүүсийг боловсролын, сэтгэлгээний, соёлын зэрэг нийгмийн сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах
6. Нийгмийн нийт гишүүдийн хувь хүний, мэдээллийн халдашгүй бүрэн бүтэн байдлыг дээдлэх шинэ мэдлэг, соёлд сургах, мэргэжлийн, мэдээллийн технологи, ёс зүйн, оюуны өмч, зохиогчийн эрхийн асуудал гэсэн нийгмийн харилцааны шинэ харилцааны орчин бүрдүүлэх

Ашигласан материал

Монгол улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, холбогдох бодлогын баримт бичгүүд

Вейб хуудас

1. www.1000ventures.com
2. www.med.govt.nz
3. www.kei.org
4. www.web.worldbank.org
5. www.hdr.undp.org
6. www.worldbank.kan

Хүснэгт 1. Дэлхийн улс орнуудын Мэдлэгийн Эдийн Засгийн Индекс, 1995, 2007

Knowledge Economy Index (KEI) 2007 Rankings

Table 1
Knowledge Economy Index (KEI) 2007 Rankings

Country	2007 Rank	KEI 2007	1995 Rank	Change from 1995	Country	2007 Rank	KEI 2007	1995 Rank	Change from 1995
Sweden	1	9.26	9	8	Tunisia	71	4.52	76	5
Denmark	2	9.22	1	-1	Kazakhstan	72	4.5	75	3
Norway	3	9.17	4	1	Philippines	73	4.48	75	-8
Finland	4	9.07	2	-2	Peru	74	4.43	73	-1
Netherlands	5	9.02	3	-2	China	75	4.42	104	29
Switzerland	6	8.99	5	-1	Georgia	76	4.4	74	-2
Canada	7	8.94	7	0	Colombia	77	4.32	64	-13
Australia	8	8.88	11	3	Venezuela, RB	78	4.26	71	-7
United Kingdom	9	8.8	10	1	Mongolia	79	4.23	98	19
United States	10	8.8	8	-2	Guyana	80	4.21	71	-19
New Zealand	11	8.76	5	-3	Sri Lanka	81	4.03	87	6
Iceland	12	8.71	28	16	Namibia	82	3.94	75	3
Austria	13	8.58	13	0	Egypt, Arab Rep.	83	3.93	81	-2
Ireland	14	8.56	18	4	Botswana	84	3.92	80	-4
Germany	15	8.54	14	-1	El Salvador	85	3.88	83	-2
Belgium	16	8.46	12	-4	Bolivia	86	3.78	79	-7
Japan	17	8.46	17	0	Kyrgyz Rep.	87	3.63	76	-1
Luxembourg	18	8.39	19	1	Dominican Republic	88	3.62	89	1
Taiwan, China	19	8.37	15	-4	Azerbaijan	89	3.56	88	-1
France	20	8.36	16	-4	Morocco	90	3.3	94	4
Hong Kong, China	21	8.19	22	1	Indonesia	91	3.29	92	1
Israel	22	8.16	20	-2	Uzbekistan	92	3.27	90	-2
Slovenia	23	8.16	27	4	Ecuador	93	3.26	82	-11
Spain	24	8.09	21	-3	Albania	94	3.22	170	6
Estonia	25	8.07	25	0	Paraguay	95	3.19	77	-18
Italy	26	7.98	23	-3	Honduras	96	3.15	85	-1
Korea, Rep.	27	7.74	24	-3	Vietnam	97	3.1	108	12
Hungary	28	7.64	32	4	Iran, Islamic Rep.	98	3.09	102	4
Czech Republic	29	7.64	29	0	Algeria	99	3.07	107	8
Cyprus	30	7.63	31	1	Nicaragua	100	3.01	101	1
Lithuania	31	7.48	43	12	India	101	3	7	-4
Portugal	32	7.44	26	-6	Cape Verde	102	2.88	99	-3
Latvia	33	7.37	52	19	Guatemala	103	2.83	103	0
Greece	34	7.29	30	-4	Syrian Arab Republic	104	2.82	105	4
Poland	35	7.24	38	3	Swaziland	105	2.77	91	-14
Slovak Republic	36	7.22	33	-3	Kenya	106	2.73	106	0
Barbados	37	7.17	44	7	Zimbabwe	107	2.48	93	-14
Croatia	38	7.09	42	4	Tajikistan	108	2.42	105	3
Chile	39	6.74	37	-2	Senegal	109	2.38	111	2
Malaysia	40	6.23	53	13	Madagascar	110	2.37	122	12
Bulgaria	41	6.18	47	6	Lesotho	111	2.23	115	5
Qatar	42	6.17	50	8	Uganda	112	2.05	124	12
Uruguay	43	6.11	35	-8	Ghana	113	1.99	114	1
Dominica	44	6.08	86	22	Pakistan	114	1.89	110	-4
Costa Rica	45	6.02	36	-9	Nigeria	115	1.84	112	-3
Kuwait	46	6.01	51	5	Tanzania	116	1.7	127	11
Russian Federation	47	5.94	55	8	Mauritania	117	1.67	126	9
Romania	48	5.86	56	8	Benin	118	1.62	115	-3
United Arab Emirates	49	5.78	40	-9	Yemen Rep.	119	1.62	120	1
South Africa	50	5.64	41	-9	Cote d'Ivoire	120	1.54	117	-3
Ukraine	51	5.58	57	6	Angola	121	1.49	137	16
Bahrain	52	5.56	34	-18	Zambia	122	1.47	116	-26
Turkey	53	5.56	60	7	Cameroon	123	1.46	121	-2
Brazil	54	5.5	58	4	Sudan	124	1.39	135	11
Argentina	55	5.49	39	-16	Myanmar	125	1.35	139	4
Thailand	56	5.41	48	-8	Malawi	126	1.25	125	-1
Armenia	57	5.36	70	13	Mali	127	1.22	118	-9
Macedonia, FYR	58	5.36	78	20	Mozambique	128	1.18	131	3
Mexico	59	5.35	45	-14	Lao PDR	129	1.17	136	7
Trinidad and Tobago	60	5.33	46	-14	Bangladesh	130	1.14	133	3
Belarus	61	5.33	69	8	Nepal	131	1.13	123	-8
Jordan	62	5.19	67	5	Burkina Faso	132	1.08	132	0
Oman	63	5.12	72	9	Eritrea	133	0.93	119	-14
Mauritius	64	5.08	63	-1	Rwanda	134	0.84	130	-4
Jamaica	65	5.04	59	-6	Djibouti	135	0.79	113	-22
Lebanon	66	5.03	54	-12	Ethiopia	136	0.74	174	-2
Panama	67	4.98	49	-18	Sierra Leone	137	0.62	128	-9
Serbia and Montenegro	68	4.98	62	-6	Singapore	138	n/a	n/a	0
Saudi Arabia	69	4.76	68	-1	Bosnia and Herzegovina	139	n/a	n/a	0
Moldova	70	4.64	84	14	Haiti	140	n/a	n/a	0

Source: KAM 2007 (www.worldbank.org/kam)

Хүснэгт 2. Монгол улсын мэдлэгийн эдийн засгийн индекс 1995, 2007 онуудад

Хэмжигдэхүүн	Монгол (хамгийн сүүлийн мэдээгээр) (Бүлэг: Бүх улс)		Монгол 1995 (Бүлэг: Бүх улс)	
	Бодит	Хэвийн болгох	Бодит	Хэвийн болгох
ДНБ-ий жилийн өсөлт (%)	5.50	7.41	6.60	8.63
Хүний хөгжлийн индекс	0.691	2.97	0.636	3.05
Тарифт болон тарифт бус саад	70.00	5.33	50.00	2.20
Зохицуулалтын чанар	-0.32	3.71	-0.71	1.64
Хуулийн хэрэгжилт	-0.26	4.86	0.43	6.71
Техникийн сэтгүүлийн өгүүллүүд/ сая хүн амд ногдох	3.20	2.88	2.61	2.45
Патентийн баталгаа USPTO/сая хүн амд ногдох	0.00	0.00	9.00	0.00
Насанд хүрэгчдийн БҮМТ (% 15 ба түүнээс дээш настай)	97.80	6.62	82.90	4.04
Дунд сургуульд хамрагдалтын түвшин	94.00	6.72	59.17	4.09
Ахлах сургуульд элсэлтийн түвшин	41.40	6.67	15.00	4.39
1000 хүн амд ногдох телефон хэрэглэгчид	279.30	3.00	34.20	3.07
1000 хүн амд ногдох компьютер хэрэглэгчид	133.10	6.21	3.30	2.64
1000 хүн амд ногдох интернет хэрэглэгчид	105.10	4.79	0.10	2.86